

Монгол Улсын Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 140/400/А-168/38 дугаар хамтарсан тушаалын хавсралт



САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

2018 он

АГУУЛГА

1. Оршил

2. Банкны системийн чанаргүй активын нөхцөл байдал

- 2.1. Чанаргүй зээлийн үзүүлэлт, түвшин
- 2.2. Чанаргүй активын өсөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлс, шалтгаан
- 2.3. Чанаргүй активыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

3. Стратегийн зорилго, тэргүүлэх чиглэл

- 3.1. Чанаргүй зээлийг бууруулах ерөнхий зорилго, стратеги
- 3.2. Стратегийн тэргүүлэх чиглэл

4. Хууль, эрх зүй, шүүхийн шинэчлэлийн зорилтууд

- 4.1. Өр төлбөрийг албадан барагдуулах ажиллагааг сайжруулах шүүх, хууль, эрх зүйн өөрчлөлт хийх
- 4.2. Дампуурлын эрх зүйн орчныг үр дүнтэй болгох

5. Чанаргүй зээлтэй ажиллах ажиллагааг үр дүнтэй болгон сайжруулах бусад чиглэлийн зорилтууд

- 5.1. Чанаргүй активтай ажиллах банкнуудын удирдлага, чадварыг сайжруулах
- 5.2. Шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох
- 5.3. Чанаргүй активын зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлэх
- 5.4. Зээлдэгчийн талаарх мэдээлэлд хандах боломжийг нэмэгдүүлж, чанаргүй зээлтэй ажиллах үр дүнг сайжруулах

6. Ажлын төлөвлөгөө

7. Стратегийн хэрэгжилтийг хянах

Товчилсон нэр

АЧҮ	Активын чанарын үнэлгээ
АУК	Актив удирдлагын компани
ЗМС	Зээлийн мэдээллийн сан
МБ	Монголбанк
МУ	Монгол Улс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон улсын валютын сан
ӨСХ	Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр
УИХ	Улсын Их Хурал
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба

1. Оршил

МУ-ын санхүүгийн системийн 95 хувийг банкны зах зээл эзэлж байгаа бөгөөд 2018 оны нэгдүгээр улирлын эцсийн байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 1.1 их наяд төгрөг болсон нь нийт активын 3.7 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 7.6 хувийг, хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.7 хувийг эзэлж байна. Зээлдэгчийн төлбөрийн чадвараас шалтгаалан хугацаа сунгасан болон өнөөдөр хугацаа хэтэрч байгаа зээлийн чанар цаашид муудахад чанаргүй зээл тэр хэмжээгээр нэмэгдэж болзошгүй.

Чанаргүй зээл нь банкны актив хөрөнгийг бууруулах, банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийг хорогдуулж, улмаар банкны тогтолцооны төлбөрийн чадварт шууд нөлөөлөх үр дагавартай тул эрсдэлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн шинэ зээл олгох эх үүсвэрийг хязгаарлаж, зээл олголт зогсох гол хүчин зүйл болж, улмаар санхүүгийн зуучлалыг багасгаж, эдийн засгийн өсөлтийг сааруулах тул тухайн улсын санхүүгийн системийн найдвартай байдал, зах зээлийн гэнэтийн таагүй нөлөөлөл, хямралын үед тогтвортой ажиллах чадварыг илэрхийлэх санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй.

Иймд чанаргүй зээлийг үр ашигтай шийдвэрлэснээр эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөхийн зэрэгцээ санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэн зөв, ил тод болгон, хуримтлал, хөрөнгө оруулалт бий болгох замаар баялагийг бүтээх, хөгжлийг бий болгох, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг мөнгө, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах чухал ач холбогдолтой юм.

Чанаргүй зээлийн хувь хэмжээ нэмэгдэж, эрсдэл даах чадвар сулрахад банк зээл олголт хумьж, зээлийн барьцаа хөрөнгөд хэт өндөр шаардлага тавьж, эрсдэл өндөртэй салбарт нэмэлт санхүүжилт олгохоос зайлсхийдэг. Манай орны банкны салбарт энэ хандлага мөн ажиглагдаж байгаа бөгөөд 2010 оны эцэст зээл банкны активын 66 хувийг бүрдүүлж байсан бол өнгөрсөн оны эцэст 47 хувьд хүрч, 19 нэгжээр буурлаа.

Сүүлийн хоёр жил эдийн засгийн голлох салбар болох уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарт олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувь 6 нэгжээр буурч, 40 хувьд хүрсэн бол эсрэгээрээ хэрэглээ, үндсэн хөрөнгө санхүүжүүлэх зорилготой иргэдийн зээлийн хувь 4 нэгжээр нэмэгдэн, 46 хувьд хүрлээ. Ирээдүйд баялаг бүтээх, хөрөнгө оруулалтын зориулалттай бодит секторын зээл хумигдаж буй үндсэн шалтгаан нь аж ахуйн нэгжид олгосон зээлийн эрсдэл иргэдийн зээлийн эрсдэлээс харьцангуй өндөр байгаатай холбоотой. Тодруулбал, 2017 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар аж ахуйн нэгжийн зээлийн 7.2 хувь, иргэдийн зээлийн 3.3 хувь нь тус тус чанаргүй ангилалд байна.

Чанаргүй зээл өсч, бодит секторт зээл олголт багасахад эдийн засгийн голлох үзүүлэлтүүд огцом буурдаг болох нь олон улсын туршлагаар батлагдсан. Жишээлбэл, Төв болон Зүүн Европын оруудын (*Central, Eastern,*

South-Eastern) 1998-2011 оны¹ нөхцөл байдалд хийсэн судалгаа, нефть олборлогч орнуудын (*Gulf Cooperation Council*) 1995-2008 оны² эдийн засгийн хөгжилд хийсэн дүгнэлт, хөгжиж байгаа орнуудын (*Emerging market*) 1966-2010 оны туршлага³ зэргээс харахад чанаргүй зээлийн өсөлт нь санхүүгийн зуучлалыг зогсонги байдалд оруулж, эдийн засгийн идэвхжлийг сулруулан, бодит секторын өсөлтийг хязгаарлаж, ажилгүйдлийг нэмэгдүүлэх нөлөөтэйг тогтоосон байна. Үүнээс үзэхэд, чанаргүй зээлийн өсөлт нь зах зээлийн бүтэц, онцлог, газар зүйн байршлаас үл хамааран улс орны эдийн засгийн хөгжлийг сааруулах нөлөөтэй болно.

Түүнчлэн, Зүүн өмнөд Азийн орнуудын туршлагын⁴ судалгаагаар санхүүгийн салбарын чанаргүй зээлийн харьцаа 1 нэгжээр нэмэгдэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 12 сарын дараа 0.2 нэгжээр буурч байгаа нь тогтоогджээ. Үүнээс гадна Мексик улсын 2000-2010 оны дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн 70 орчим хувийг зээл олголтоор тайлбарлаж болохоор байсан байна⁵. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээл сул хөгжсөн орнуудын эдийн засгийн тэлэлтэд зээл олголт хамгийн чухал үзүүлэлт болж байна.

2010 онд чанаргүй зээл өмнөх оноос 61 хувиар буурч, 19.9 хувиас 6.7 хувь болж, зээл эргэн төлөлтийн орчинд томоохон эерэг өөрчлөлт гарсан нь 2011 онд зээлийн өсөлт 75 хувьд хүрч, бодит эдийн засгийн өсөлт 17.3 хувьтай гарахад чухал нөлөө үзүүлсэн.

Гэвч манай оронд чанаргүй зээл 2013 оны дундаас өнөөдрийг хүртэл тасралтгүй өссөн нь зээл олголтыг бууруулан, эдийн засгийн хүндрэлийг гүнзгийрүүлж, эргээд зээлийн эргэн төлөлтийг доголдуулах хамаарал (*vicious cycle*) хүчтэй ажиглагдаж байна. ОУВС-гаас Төв болон Зүүн Европын 16 орны⁶ 1998-2011 оны туршлагад хийсэн судалгаагаар эдийн засагт чанаргүй зээлийн хувь 1 нэгжээр нэмэгдэхэд ажилгүйдлийн түвшин гурван жилийн дотор 0.5 нэгжээр, эдийн засгийн өсөлт хоёр жилийн дотор 1 нэгжээр буурсныг тогтоожээ. Харин зээл, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 1 нэгжээр нэмэгдэх буюу зээл олголт сэргэхэд чанаргүй зээлийн хувь 0.7 нэгжээр

¹ Nonperforming loans in CESEE: Determinants and impact on macroeconomic performance, *Nir Klein*, 2013

² Nonperforming loans in the GCC banking system and their macroeconomic effects, *Raphael Espinoza and Ananthakrishnan*, 2010

³ Bank asset quality in Emerging markets: Determinants and spillovers, *Reinout De Bock and Alexander Demyanets*, 2012

⁴ PPT presentation, ADB-China Huarong jointly hosted the Financial Stability Seminar on Managing NPLs in Asia and Europe, Shanghai, PRC

⁵ Spillovers and Long Run Diffusion of Non-Performing Loans Risk, *Renata Herreras and Jorge O. Moreno*, 2011

⁶ “Non-Performing Loans in CESEE: Determinants and Impact on Macroeconomic Performance,” *Klein, Nir*, IMF Working Paper WP/13/72, 2013

буурах төлөв ажиглагдаж байсан байна. Энэ үр дүнг үндэслэвэл, МУ 2014-2016 онд жилд дунджаар 5-6 хувийн эдийн засгийн боломжит өсөлтөө алдсан байна. Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд үндэсний орлого 19 орчим хувиар өсөх боломжтой байжээ. Цаашид чанаргүй зээл нэмэгдэж, нийт зээлийн 10 хувийг давах тохиолдолд 2019-2020 он хүртэл эдийн засагт идэвхжил гарахгүй байх магадлалтай.

Мөн чанаргүй зээл нэмэгдэхэд зээлээ хугацаанд нь төлдөг хариуцлагатай зээлдэгчид чанаргүй зээлтэй холбоотой, түүнийг шийдвэрлэхэд зарцуулах үргүй зардлыг дам хариуцан төлж байдаг.

Зээл олголт буурах нь зээлийн хүү өсөх суурь нөхцөл болдог бөгөөд үүний үр дүнд зээлдэгчид өндөр хүү, шаардлага бүхий банкнаас зээл авах нь багасч, зээлийн бусад эх үүсвэрийг хайж эхэлдэг. Энэ нь эргээд зээлдэгчдийг эрсдэлд оруулдаг байна.

Тиймээс чанаргүй зээлийг бууруулж, зээл олголтыг нэмэгдүүлэн, санхүүгийн зуучлалыг сэргээх зайлшгүй шаардлага тулгараад байна. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхгүйгээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, татварын орлогыг нэмэгдүүлж, өрийн тэнцвэрт байдалд хүрэхэд хүндрэлтэй болно.

Зээлийн эргэн төлөлт доголдож байгаагаас шалтгаалан банкны системийн эрсдэлийн сангийн зардал тасралтгүй нэмэгдэж байна. Тухайлбал, банкнууд 2013 онд 45 тэрбум төгрөгийг зээлийн алдагдлаас хамгаалах сангийн зардалд зарцуулж байсан бол 2017 онд энэ үзүүлэлт 356 тэрбум төгрөг болж, 7.9 дахин өссөн. Үүнтэй зэрэгцэн өнгөрсөн хугацаанд банкнуудын ашигт ажиллагаа огцом буурсан нь зээлийн хүү буурах боломжийг хааж байна.

Үүний үр дүнд банкны салбарт тогтворгүй байдал үүсч, зах зээлд агшилт гүнзгийрэх нь МУ-ын зээлжих зэрэглэлийг өсгөж, санхүүжилтийн зардлыг бууруулах тулгамдсан арга хэмжээнд сөргөөр нөлөөлж, банкны салбараас эх үүсвэр гадагшлах нөхцөлийг бүрдүүлнэ.


2. Банкны салбарын чанаргүй активын нөхцөл байдал

2.1. Чанаргүй зээлийн үзүүлэлт, түвшин

Банкны салбарын нийт чанаргүй зээлийн хэмжээ 2018 оны нэгдүгээр улирлын эцсийн байдлаар 1.1 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн 7.6 хувийг эзэлж байгаа бол хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 938.7 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн 6.7 хувийг бүрдүүлж байна (Зураг 1, 2). Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28.4 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 5.2 хувиар буурчээ.


Зураг 1

Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн нийт үлдэгдэл (тэрбум төгрөг)



Зураг 2


Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн хувь (%)



Зээлийн чанарыг эдийн засгийн салбараар авч үзвэл, тайлант улирлын эцэст боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилгын салбарт олгосон нийт зээлийн харгалзан 16.7, 15.3, 11.2 хувь нь чанаргүй гэж ангилагдсан бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ нь 502.0 тэрбум төгрөгт хүрч, банкны салбарын нийт чанаргүй зээлийн 47.1 хувийг бүрдүүлж байна (Зураг 3). Түүнчлэн боловсруулах үйлдвэрлэлийн болон барилгын салбарын зээлийн чанар 2016 оны дундаас муудаж, чанаргүй зээлийн хувь тус тус 16.7, 11.2 хувьд хүрээд байна. Эдгээр салбарын нийт чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 50 хувиар өсчээ.

Зураг 3

Зээлийн чанар, эдийн засгийн салбараар (%)




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн чанарыг зээлдэгчийн хэмжээгээр авч үзэхэд, сүүлийн жилд орлого багатай жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдэд олгосон зээлийн

эргэн төлөлтийн доголдол өндөр байна. Тухайлбал, 2018 оны нэгдүгээр улирлын байдлаар ЖДҮ-ийн зээлийн 29.4 хувь буюу 228.7 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгджээ. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 131.4 хувь буюу 129.9 тэрбум төгрөгөөр өсчээ. ЖДҮ-ийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн 5.6 хувийг бүрдүүлж байгаа боловч чанаргүй зээлийн 21.5 хувийг эзэлж байна. Тус үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 9.6 нэгжээр нэмэгдсэнээс үзэхэд бага, дунд орлоготой хувиараа бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар сайжрахгүй байгааг харуулж байна.

Зураг 4




Эх сурвалж: Монголбанк


Гадаад валютын ханшийн хэлбэлзэл гадаад валютаар олгосон зээлийн чанарт ихээхэн нөлөөлдөг. 2014 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн МУ-ын банкны салбарын зээлийн чанар муудаж эхэлсэн бөгөөд үүнд эдийн засгийн таагүй нөхцөл байдал болон төгрөгийн ханшийн огцом сулралтаас үүдэлтэйгээр гадаад валютаар олгосон зээлийн чанар муудсан нь голлон нөлөөлсөн.

2018 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар гадаад валютын чанаргүй зээл нь нийт гадаад валютаар олгосон зээлийн 10.6 хувийг эзэлж байна. Энэ нь төгрөгийн нийт зээлд төгрөгийн чанаргүй зээлийн эзлэх хувиас 3.8 нэгж хувиар өндөр байна.

Зураг 5



Зураг 6



Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн хувь хэмжээ сүүлийн жилүүдэд өссөнөөр банкны салбарын хүлээх алдагдал нэмэгдэж, улмаар төрд учрах хохирлыг нэмэгдүүлж болзошгүй байна. АЧҮ-ний үр дүнгээр банкнуудын активын эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч болзошгүй байгаа нь банкнууд

активаа буруу үнэлж байсныг илэрхийлж байна.

Уул уурхай, барилгын салбарын зээл илүү чанаргүйдсэн байна. 2017 оны эцэст байгууллагын зээлээс уул уурхай, олборлолтын салбарт олгосон зээлийн 14.8 хувь чанаргүй болсон нь тус салбараас үүссэн эрсдэл банкны салбарт өндөр хувьтайг (нийт чанаргүй зээлийн 13.9 хувь) илтгэж байгаа бөгөөд тухайлсан банкны хувьд бүр ч өндөр байх тул уул уурхайн салбарын санхүүжилтийг банкны өндөр хүүтэй, богино хугацаатай зээлээр санхүүжүүлэх нь зохимжгүй болох нь харагдаж байна. Уул уурхайн бизнесийн санхүүжилтээс шалтгаалсан банкнуудын дампуурлын жишээ ч олон байгаа нь уул уурхайн салбарын зээлд тусгай зохицуулалт байж болохыг харуулж байна.

Иргэдийн хэрэглээний зээлийн хувьд цалин, тэтгэврийн зээл нь үндсэндээ барьцаагүй бөгөөд тухайн иргэн өрийн тойрогт орсноор амьжиргааг нь улам дордуулж байх магадлалтай тул эдгээр хэрэглээний зээлд тусгай хязгаарлалт, зохицуулалт шаардлагатай байж болох юм.

Банкны системийн нийт зээлийн 90 орчим хувь нь барьцаагаар баталгаажсан хэдий ч 2004-2014 оны мэдээнээс үзэхэд муу зээлийн зөвхөн 35 орчим хувь нь эргэн төлөгдсөн байна. Үүнд чанаргүй зээлтэй холбоотой асуудлыг шүүхийн бус журмаар, эсхүл түргэвчилсэн процессоор шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт манай оронд байхгүй байгаа нь голлон нөлөөлсөн. Тодруулбал, зээлдэгч зээлийн барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, холбогдох шийдвэрийг гаргуулан, шийдвэр гүйцэтгэлийн арга хэмжээ авах хүртэл ихээхэн хугацаа шаардагдахаас гадна зардал өндөртэй, барьцааны үнэлгээг бууруулах сөрөг үр дагавартай байдаг.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн орчны хүрээнд чанаргүй зээл шийдвэрлэх иргэний хэргийн ажиллагаа ямар нэгэн сааталгүй явагдахад хамгийн багадаа 4 сарын хугацаа шаардлагатай⁷ байдаг. Энэ хугацаанд нэхэмжлэгч болон хариуцагчийн хүсэлтээр шүүхийн ажиллагаа олон удаа хойшлох нь түгээмэл юм. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад хөрөнгийн үнэлгээ болон ашиг сонирхлын зөрчлөөс үүдэн маргаан гарч, 3 шатны шүүхээр дахин шийдвэрлүүлэх тохиолдол гардаг. ШГА удаан хугацаанд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулдагаас шалтгаалан зээлийн үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээр хангуулах хугацаа 7 жил хүртэл удаашрах тохиолдол гарч байна.

2.2. Чанаргүй активын өсөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлс, шалтгаан

Чанаргүй актив гэдэгт чанаргүй зээл, бусад актив, тэнцлийн гадуурх үүрэг хамаарна.

Гадаад орчны хүчин зүйлс

- Макро эдийн засгийн уналт:

⁷ Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71.1 дэх зүйл

- Эдийн засгийн уналт буюу дотоодын нийт бүтээгдэхүүний бууралт,
- Төгрөгийн ханшийн сулралт,
- Нүүрс, зэсийн үнийн уналт, экспортын агшилт,
- Макро эдийн засгийн тогтворгүй байдлаас улбаалсан зээл олгох эх үүсвэрийн өндөр өртөг,
- Улс төрийн шалтгаанаар тухайлсан салбарууд болон санхүүгийн зах зээлд хөтөлбөр зэрэг арга хэмжээ хэрэгжүүлснээс үүдсэн санхүүжилтийн өртгийн ялгаа.
- Чанаргүй активын зах зээл хөгжөөгүй,
- Шүүхийн бус журмаар өр төлбөр барагдуулах тогтолцоо хөгжөөгүй,
- Шүүхийн журмаар өр төлбөр барагдуулах хууль зүйн ажиллагааны хүндрэл их. Үүнд:
 - Давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах зэргээр шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг хуульд заасны дагуу уртасгах боломжтой,
 - Шүүх хурлыг хойшлуулах замаар хурал хийлгэхгүй байх тактик, практик боломж их,
 - Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаа нь хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гаргуулахаас илүү хүндрэлтэй,
 - Шүүхийн шийдвэр гарснаас хойш хүү тооцогддоггүй.
- Уул уурхайн салбарт олгосон зээлийг богино хугацааны эх үүсвэрээр санхүүжүүлсэн,
- Чанаргүй активтай холбоотой татварын зохицуулалт байхгүй,
- Зээлийн өсөлт сүүлийн 4 жил хэт өндөр байсан, хөтөлбөрийн зээлүүд бий болсон,
- Эдийн засгийн төрөлжилт хангалтгүй зэрэг болно.

Банкны дотоод хүрээнд

Банкнууд дотооддоо өөрийн журам, заавраа мөрдөхгүй, зохистой засаглалыг хэрэгжүүлэх хүсэл сул байх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрэн хэрэгжүүлдэггүй, банкны хувь нийлүүлэгч, холбогдох этгээдийн зээлийг хязгаарлалтаас давуулан олгох, ил, далд байдлаар түүнийгээ зохицуулах нэрээр нуух зэргээр дотоод зөрчлөө гүнзгийрүүлдэг, анхнаасаа зээлийн судалгаа, олголт нь банкны дотоод дүрэм, журмаа баримтлаагүй зэргээр чанаргүй активыг бий болгодог. Түүнчлэн банкнуудын эрсдэлийн удирдлага сул байгаа бөгөөд зээлдэгчийн мөнгөн урсгалыг тооцохгүйгээр барьцаа хөрөнгөнд хэт анхаарах, барьцаа хөрөнгийн үнэлгээ хангалтгүй, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл хязгаарлагдмал, үнэлгээний аргачлал, стандарт чанарын шаардлага хангадаггүй.

Иймд банкнуудын чанаргүй зээл өсөхөд гадаад орчны нөхцөл байдал

болон банкнуудын өөрсдийн удирдлага, үйл ажиллагааны асуудал аль аль нь нөлөөлсөн гэж үзэхээр байна.

2.3. Чанаргүй активыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжсэнээс хойш 33 банкинд зөвшөөрөл олгосны тал нь буюу 14 банк одоо ажиллаж, бусад нь дампуурахад тухайн банкны чанаргүй актив голлон нөлөөлсөн байдаг.

МУ дахь банкны системийн чанаргүй активын түвшин өндөр, түүнд нөлөөлөх хүчин зүйлс нь харьцангуй өргөн хүрээг хамарсан тул чанаргүй активыг шийдвэрлэх иж бүрэн стратеги боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага үүсч байна.

Чанаргүй активыг шийдвэрлэх стратеги нь ОУВС, МУ хамтран хэрэгжүүлж буй ӨСХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх санхүүгийн салбарын стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм.

Иж бүрэн стратеги боловсруулахын тулд өргөн хүрээний бодлогын арга хэмжээг авч үзэх шаардлагатай тул холбогдох яамд, МБ, төрийн байгууллагууд, Банкны холбооны хамтарсан ажлын хэсгийг байгуулахаар төлөвлөсөн.

МБ, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яамны хамтарсан ажлын хэсгээс чанаргүй актив, зээлийг бууруулах хууль, эрх зүйн, институцийн болон хэм хэмжээний одоогийн бэрхшээл, саадыг арилгах зорилгоор хууль, эрх зүйн өөрчлөлт, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын тогтолцоо, институцийн өөрчлөлт зэрэг олон чиглэлийн хүрээнд чанаргүй зээлийг үр дүнтэй шийдвэрлэх орчныг сайжруулах стратеги буюу товчоор “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг” (цаашид стратеги гэх)-ийг ойрын 3 жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийн хамт боловсруулсан.

Стратеги нь дараах шат дараалалтай байна. Үүнд:

- Чанаргүй активыг үр дүнтэй шийдвэрлэхэд тулгарч байгаа хууль, эрх зүй, татвар, бүртгэлийн бэрхшээл, саад тогторыг тодорхойлох, үндсэн зорилтыг тодорхойлсон бичиг баримтыг бэлтгэх,
- Стратегийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагуудаас хамаарах бодлого, арга хэмжээний жагсаалт гаргах,
- Бодлого, арга хэмжээг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх,
- Стратегийн гүйцэтгэлийг байгууллага тус бүр болон ажлын хэсэг хариуцан хэрэгжүүлэх.

3. Стратегийн зорилго, тэргүүлэх чиглэл

3.1. Чанаргүй зээлийг бууруулах ерөнхий зорилго, стратеги

Энэхүү стратегийн зорилго нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаа чанаргүй активыг үүсгэдэг суурь шалтгаан, саад бэрхшээлийг тодорхойлох, чанаргүй активтай холбоотой асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд тулгарч байгаа тэдгээр саад бэрхшээлийг арилгах замаар зөөлөн дэд бүтцийн үр ашигтай, тогтвортой байдлыг сайжруулах, банк төдийгүй иргэн, хуулийн этгээд, төр зэрэг бусад зээлдүүлэгчийн зардлыг бууруулах замаар зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх, зээл олголтыг нэмэгдүүлэх, иргэд, байгууллагын бизнесийн орлогыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оршино.

Стратегийн тоон зорилт: Банкны системийн чанаргүй зээлийн хувийг 2021 он гэхэд 4-5, 2023 он гэхэд 2-3 хувь хүртэл бууруулах.

Стратегийн чанарын зорилт: Банкнууд чанаргүй активаа үр дүнтэйгээр шийдвэрлэх тогтолцоо илүү тодорхой болж, одоогийн саад, бэрхшээлүүд шийдэгдэж, чанаргүй активыг шийдэх боломж, арга хэлбэр өргөжиж, авлага барагдуулах хугацаа багасч, зарцуулах зардал буурах нөхцөл бүрдэнэ.

3.2. Стратегийн тэргүүлэх чиглэл

Ерөнхий зорилгод хүрэхдээ дараах үндсэн хоёр чиглэлээр зорилтуудыг тодорхойлно. Үүнд:

Хууль, эрх зүйн чиглэлд:

- Өр төлбөрийг шүүхийн журмаар албадан барагдуулах ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгох зорилгоор хууль, эрх зүйн болон шүүхийн тогтолцоонд шаардлагатай өөрчлөлт оруулж, боловсронгуй болгон сайжруулах,
- Татварын зохицуулалтын бэрхшээл, саадыг арилгах, бууруулах,
- Дампуурлын хууль, эрх зүйн орчныг үр дүнтэй, боловсронгуй болгон сайжруулах,
- Дээр дурдсан чиглэлээр дараах хууль тогтоомжийг боловсронгуй болгох:
 - Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
 - Арбитрын тухай хууль
 - Компанийн тухай хууль
 - Дампуурлын тухай хууль
 - Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль
 - Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль
 - Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
 - Хөрөнгийн үнэлгээний тухай хууль

- Татварын хууль тогтоомж
- Барьцаа хөрөнгийг шүүхийн бус замаар худалдан борлуулах эрх зүйн орчин
- Шаардлагатай бусад хууль тогтоомж.

Эдгээр хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбогдуулан оролцогч байгууллагуудын хүрээнд дэд ажлын хэсгүүд байгуулан, тус хуулиудад ямар өөрчлөлт оруулах талаар нарийвчлан судалж, “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгаа, эсхүл хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсний үндсэн дээр холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх арга хэмжээ авна.

Бусад чиглэлд:

- Чанаргүй активтай ажиллах банкнуудын чадвар, удирдлагыг сайжруулах.
Тухайлбал:
 - Зээл чанаргүйдэхээс анхнаас нь сэргийлэхийн тулд зээлийг олгох эрсдэлийн удирдлагыг сайжруулах,
 - Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах журамд активын чанар муудсаныг цаг алдалгүй тогтоох шаардлагыг сайжруулах.
- Шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон нийтэд сурталчлах,
- Чанаргүй активын зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлэх:
 - Чанаргүй активын бүтэц өөрчлөх зохицуулалтыг боловсронгуй болгон сайжруулах,
- Зээлдэгчийн талаарх мэдээлэлд хандах боломжийг нэмэгдүүлэх замаар чанаргүй зээлтэй ажиллах үр дүнг сайжруулах.

4. Хууль, эрх зүй, шүүхийн шинэчлэлийн зорилтууд

Банкны салбарын эрх зүйн орчныг сайжруулж, илүү үр ашигт механизмыг бүрдүүлэх зорилгоор МБ-наас 11 хуульд өөрчлөлт, шинэчилсэн найруулга оруулахаар ажиллаж байна. Үүнээс нэг хуулийг УИХ-аар баталсан. “Активын удирдлагын тухай хууль”-ийн төслийг шинээр боловсруулсан бөгөөд төрөөс 2018 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд заасан “Банкийг дахин хөрөнгөжүүлэх тухай хууль”-ийг УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Эдгээрээс гадна шүүхэд хандах өр төлбөр барагдуулах тогтолцоог сайжруулах, хугацааг богино болгох, барьцаатай боловч барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагаа шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд олон жилээр сунжран удааширдаг саад бэрхшээлийг арилгах, татвар, бүртгэлийн зэрэг саад бэрхшээлийг арилгах чиглэлээр шаардлагатай хуулиудад

нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага тулгарч байна.

Түүнчлэн, тусгайлсан шүүх байгуулах шаардлага, шүүгчдийн эдийн засгийн суурь ойлголтыг дээшлүүлэх, хуулийн этгээд болон хувь хүний дампуурлын тухай асуудлыг ч авч үзэх нь эдийн засгийн өсөлтийг шүүх, хууль, эрх зүйн тогтолцоог сайжруулах замаар дэмжих ач холбогдолтой.

Чанаргүй зээлийг шийдвэрлэх орчин, хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь урт хугацааны санхүүгийн хөгжлийн үндэс суурийг бүрдүүлдэг тул дараах өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна.

4.1. Өр төлбөрийг албадан барагдуулах ажиллагааг сайжруулах шүүх, хууль, эрх зүйн өөрчлөлт хийх

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах тогтолцоог зээл тус бүрт хэрэгжүүлэх боломжтой байгаа нь ихээхэн хугацаа алдахад хүргэж байна.

Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн процесс тус бүрт шүүх хурлыг хойшлуулах, шүүгчээс татгалзах олон аргыг хэрэглэснээр шүүхээр асуудал шийдэх хугацааг уртасгаж байна.

Хурал хойшлох удаашрах дараах тохиолдлууд байдаг. Үүнд:

- хариуцагч өвдөх, томилолтоор явах
- өмгөөлөгч авах, өмгөөлөгч өвдөх, томилолтоор явах, хурал давхцах
- хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч солигдох
- хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч солигдох тухай бүрд хэргийн материалтай танилцах хугацаа авах
- шүүгчээс татгалзах
- тухайн шүүхээс татгалзах
- шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэргийг хэдэн ч удаа анхнаас нь эхлүүлж болох
- шинжээч томилуулах
- шинжээч солих гэх мэтээр үргэлжлэх бөгөөд эдгээрийг олон удаа давтан хэрэглэдэг

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг ШГА-тай гэрээ байгуулж, хэрэгжүүлэх нь ихэнх тохиолдолд хугацаа, зардал шаардсан арга хэмжээ болдог байсныг 2017 оны батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиар албан тушаалтан өөрийн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө урамшуулал авдаг, урамшууллын хэмжээг харилцан тохиролцоохын тулд гэрээ байгуулдаг, гэрээ байгуулаагүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлдэггүй байсныг өөрчилж, огт урамшуулалгүй байхаар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гомдол гаргаж, ажиллагааг удаашруулдаг байдлыг, төлбөр авагчид хамгийн сүүлийн дуудлага худалдааны доод үнээр худалдан борлогдоогүй хөрөнгийг санал болгодог байх зэргээр өөрчлөх зохицуулалтуудыг тусгажээ. Гэвч ШГА-нд тодорхойгүй буюу субъектээс хамаарсан асуудал үүсэх нь түгээмэл байна.

Барьцаат зээлийн хувьд ШГА-нд өгсний дараа барьцаа хөрөнгийг борлуулахад хугацаа болон зардлын хувьд ажиллагаа ихтэй. Дуудлага худалдааны журмаар барьцаа хөрөнгийг борлуулдаг боловч барьцаа хөрөнгийг борлуулах үнэлгээний асуудал хүндрэлтэй. Талууд үнэлгээн дээр тохиролцож чадаагүйгээс шинжээч томилох, дахин томилох, ШГА-ыг шүүхэд өгөх зэргээр барьцааг зарж, төлбөрөө барагдуулах хугацаа уртсаж, ажиллагаа ихтэй болдог. Хоёр удаагийн дуудлага худалдаагаар хямдруулаад ч зарагдаагүй байхад төлбөр авагч анхны үнээр төлбөрт тооцож авдаг. Илүү гарвал зөрүүг төлбөр авагч төлдөг. Үндсэндээ ШГА-нд барьцаа хөрөнгийг борлуулах ажиллагаа хүндрэл ихтэй явах нөхцөл бүрдсэн. Үүнээс шалтгаалж зээлдүүлэгчид ШГА-аас тойрох буюу ашиглахгүй байх, ашигласан ч хугацаа, боломж алдахаа зөвшөөрсөн байдлаар хандахаас өөр аргагүй болдог.

Байгууллагын тогтолцооны сул тал:

Шүүх төрөлжөөгүй, нөөцийн дутагдалтай. Иргэний шүүхээр бүх хэрэг ордог тул зээлийн харилцаагаар тусгайлан мэргэшээгүй шүүгчид хэргийг шийддэг. Шүүгчийн ачаалал их, зарим шүүх, шүүгч дээр хэт төвлөрөлтэй байдаг.

ШГА нь чадвар, санаачилга, урамшуулал, нөөцийн хувьд зээл төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хамгийн их дутагдалтай байгууллага юм.

Зээлийн хүү шүүхийн шийдвэр гарснаар зогсож, цаашид зээлдэгч зээлээ шүүхийн шийдвэрийн дүнгээр л төлдөг тул зээлдэгчид зээлээ төлөх эдийн засгийн сонирхол үүсэхгүй, харин ч удаашруулах тактикт орох нь олон. Иймд олон улсын нийтлэг жишгийн дагуу шүүхийн шийдвэр зээл төлж дуусах хүртэлх хугацааны хүүг тооцож төлүүлэхээр гардаг байх нь зээлдэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх эдийн засгийн хөшүүрэг болно.

Хийх өөрчлөлт:

- Шүүх хурлыг хойшлуулах тохиолдол тус бүрт төлбөр төлдөг болох,
- Давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах шаардлага, боломжийг багасгах,
- Шүүхэд хандахгүйгээр гэрээгээр тохирсон албадан борлуулах үнэлгээгээр барьцаа хөрөнгийг зээлдүүлэгчид шилжүүлэх зохицуулалт бий болгох,
- ШГА-нд хөрөнгийн үнэлгээг гэрээнд тохирсон үнээр цахим дуудлага худалдаагаар богино хугацаанд хийж, худалдагдаагүй тохиолдолд зээлдүүлэгчийн (төлбөр хүлээн авагчийн) өмчлөлд даруй шилжүүлэх,
- ШГА-ны дуудлага худалдаанд нэг оролцогч орсон ч хүчин төгөлдөр болдог байх,
- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны гомдлыг шүүхэд гаргах нь ажиллагааг түдгэлзүүлэх, хойшлуулах үндэслэл болдоггүй байх.

4.2. Дампуурлын эрх зүйн орчныг үр дүнтэй болгох

Одоогийн тогтолцоогоор дампуурлын хэрэг үүсгэх нь дараах саад бэрхшээлтэй байна. Үүнд:

- Зээлдэгч дампуурах нь нэхэмжлэгчид ихээхэн хүндрэл учруулдаг.
- Барьцаат зээлдүүлэгч нь дампуурлын эхний шатнаас л барьцаагүй болох магадлал өндөр.
- Дампуурлын хуулийн дагуу сүүлийн арван жилд 43 хэрэг үүссэний ихэнх нь хөрөнгөгүй этгээд байсан нь уг хууль ач холбогдол багатай байгааг илэрхийлж байна.
- Дампуурлын тусгай шүүх байхгүй.

Дампуурлын хэрэг үүсгэх нь чанаргүй активыг төлүүлэхэд ямар ч нөлөөгүй байгаа тул уг хуулийг бүхэлд нь шинэчлэн боловсруулж, зээлдүүлэгч, төлбөр авагч талд төлбөрөө авах нөхцөлийг бүрдүүлсэн тогтолцоог үүсгэх зайлшгүй шаардлагатай.

Дампуурлын хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг дутмаг байдгаас тухайн шүүгч нь дампуурлын хэрэг гүйцэтгэгч, зохигчдын өгсөн мэдээлэлд хэт түшиглэх байдал бий болдог.

5. Чанаргүй зээлтэй ажиллах ажиллагааг үр дүнтэй болгон сайжруулах бусад чиглэлийн зорилтууд

Чанаргүй зээлийг үр ашигтай шийдвэрлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүд нь зээлийн хүү өндөр тогтоход нөлөөлж байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд тусгасны дагуу МБ-наас арилжааны банкнууд болон эдийн засагчидтай хамтарч “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн төслийг боловсруулаад байна. Энэхүү стратегийн хүрээнд (i) зээлийн хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх, (ii) мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг нэмэгдүүлэх, (iii) банкны салбарын эрсдэл даах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулахад шаардлагатай эрх зүй, удирдлага, журам заавар, үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн нийт 11 зорилтыг тодорхойлсон. Уг стратеги нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийн 2018 оны зургаадугаар сарын 12-ны өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан.

Энэхүү стратеги батлагдаж хэрэгжсэнээр дунд хугацаанд зах зээлийн зарчмаар зээлийн хүү бууран, зээлийн үндсэн төлбөрөө ахиу төлөх боломж зээлдэгчдэд үүсч, чанаргүй зээлийн хэмжээ буурахад эерэг нөлөө үзүүлнэ.

Чанаргүй зээл нь банкны үйл ажиллагаа болон гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсч байгаа тул банк дотооддоо чадавхаа сайжруулах, түүнд нь МБ-наас илүү шаардлага тавьж, хянах, шүүхийн бус замаар зээлдэгчтэй ажиллаж, зардал, цаг хугацааны хохирол багатайгаар шийдэх, зээлийн бүтэц өөрчлөх

замаар зээлдэгчид илүү боломж олгох шаардлагатай байна.

5.1. Чанаргүй активтай ажиллах банкнуудын удирдлага, чадварыг сайжруулах

АЧҮ-г 2017 онд олон улсын аудитын байгууллага МБ-ны захиалгаар бүх банкинд хийсэн. Тус үнэлгээгээр банкнууд чанаргүй активаа зөв ангилаагүй, эрсдэлийн сангаа дутуу байгуулсан нь тогтоогдсон. Иймд банкнуудын чанаргүй актив, зээлтэй ажиллах ойлголт, аргачлал, мэдээ тайланг сайжруулах зорилгоор “Чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журам”-ыг МБ-наас боловсруулан, банкнуудад мөрдүүлэхээр ажиллаж байна.

Ингэснээр банкнууд чанаргүй активын асуудлыг банкны дээд шатны удирдлага болох ТУЗ, удирдлагын багийн түвшинд хэлэлцэн, чанаргүй актив үүсгэхгүй байх, чанаргүй активыг удирдах, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо болон нэгэнт үүссэн чанаргүй активыг төлүүлэх стратеги боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх тактик, зорилтыг баталж, МБ-нд хянуулдаг болно. Тухайлбал, чанаргүй активын нийт болон цэвэр дүнг бууруулах тоон зорилт бүхий стратегийг банкны ТУЗ баталж, МБ-нд тайлагнана.

МБ нь банкнуудын стратеги, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад тоон болон чанарын үзүүлэлтээр хяналт тавина. Ингэснээр МБ-наас банкнуудын чанаргүй активт илүү тодорхой, үр дүнтэйгээр хяналт тогтоох бололцоо бүрдэнэ.

Уг журмын дагуу олон нийтэд чанаргүй активын талаар банкнууд тодорхой мэдээлэл өгдөг болно. Ингэснээр банкнууд нээлттэй, ил тод болохын зэрэгцээ сонирхогч талууд илүү үр ашигтайгаар хяналт, шаардлагаа тавьдаг болно.

Банкнууд эрсдэлийн сангаар активыг хорогдуулж, тэнцлийн гадуур бүртгэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэх боломжийг шинэчлэн батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-аар олгосон. Цаашид активын чанар муудсаныг цаг алдалгүй тогтоох болон активыг тэнцлээс хасах талаар шаардлагатай сайжруулалтыг хийнэ.

Түүнчлэн зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг зах зээлийн үнэлгээгээр тогтоох аргачлалыг боловсруулах, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний шаардлага, стандартыг тогтоох зорилгоор “Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ыг баталж мөрдүүлнэ. Ингэснээр банкнууд активын чанарт шууд нөлөө үзүүлдэг гол үзүүлэлт болох барьцаа хөрөнгийн талаар илүү үр ашигтай ажиллана.

Эдгээрээс гадна Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан МБ-наас дараах журмуудыг 2018 онд шинээр боловсруулна.

Үүнд:

- Банкны томоохон харилцагч, холбогдох этгээдийг тодорхойлох, санхүүжилт олгох, хэлцэл хийх хязгаар тогтоох журам,

- Хувьцаат компани хэлбэрээр байгуулагдсан банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн болон шинэ хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах журам,
- Нэгдсэн хяналт шалгалтын журам,
- Банкныг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгах журам,
- Банкаас Засгийн газрын дахин хөрөнгөжүүлэлт хүсэх болон бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлж буй банкныг Засгийн газраас дахин хөрөнгөжүүлэх журам,
- Банкинд албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх журам,
- Банкны тогтворжуулалтын сангийн тухай журам,
- Зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх журам.

Түүнчлэн МБ-наас зээл олгохтой холбоотой эрсдэлийн удирдлагын журмыг шинээр боловсруулж байгаагаас гадна 2018 онд багтаан ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд Базел стандартын бүлэг II-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэхээр ажиллаж байна.

Банкнудын тэнцэлд чанаргүй зээл хуримтлагдаж, шийдвэрлэгдэхгүй удах эрсдэлээс сэргийлэх зарим арга хэмжээг банкны зохистой харьцааны зохицуулалтыг шинэчлэх ажлын хүрээнд судалж шийдвэрлэнэ. Тухайлбал, чанаргүй зээлд өндөр эрсдэлийн жин тогтоох, төвлөрөл ихтэй эдийн засгийн салбаруудад ялгаатай эрсдэлийн жин тогтоох зэргийг харгалзан үзнэ.

5.2. Шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох

ИНСОЛ (INSOL)-ын зарчмын дагуу шүүхийн бус журмаар чанаргүй активыг шийдвэрлэх аргачлалуудыг ашиглах тогтолцоо, практикийг хөгжүүлэх. Үүнд:

Чанаргүй зээлийн бүтэц өөрчлөх зохицуулалтыг боловсронгуй болгох (санхүүгийн дахин зохион байгуулалт)

Банкнуд өр төлбөрийн урт хугацааны бүтцийн өөрчлөлтийг хийхгүй байна. Хууль, эрх зүйн орчин нь үр дүнтэйгээр бүтэц өөрчлөх боломжийг олгохгүй байна. Авлага барагдуулах ажиллагаа болон дампуурлын тогтолцооны дутагдал нь өр төлбөрийн бүтцийг өөрчлөх хүчин чармайлтыг сулруулж байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа актив ангиллын журмын зээлийн бүтэц өөрчлөх зохицуулалт нь харьцангуй шинэ бөгөөд банкнуд өргөн ашиглаж эхлээгүй байна. Иймд энэхүү зохицуулалтыг илүү үр дүнтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх замаар зээлийн бүтэц өөрчлөх аргыг шүүхийн

бус том аргачлал болгон ашигладаг болох шаардлагатай.

Чанаргүй активтай зээлдэгчийн үйл ажиллагааны бүтэц өөрчлөх зохицуулалтыг боловсронгуй болгох

Бүтэц өөрчлөх, дахин зохион байгуулалт буюу “бизнесийг засах” аргачлал нь компанийн үр ашиггүй бизнесийн төрлөөс татгалзах, барьцаа хөрөнгийн үнэ цэнийг бууруулахгүйн тулд үйл ажиллагааг тогтоох (“цус алдалтыг зогсоох”), сайжруулах, зээлдэгчийн үйл ажиллагаанд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх, удирдлагын багийг сайжруулах, өөрчлөх, тайлан тэнцлийг сайжруулах замаар үйл ажиллагааг сэргээх зээлдэгч, зээлдүүлэгчийн харилцан гэрээгээр тохирсон үүрэг, амлалт, хяналтын хүрээнд шийдэгдэх асуудлууд байдаг.

Шүүхийн оролцоогүйгээр өр төлбөрийн үүрэг гүйцэтгэгч болон түүнээс авлагатай бүх, эсвэл зарим зээлдэгч хоорондоо гэрээ хийж, хяналт, тайлагнал, удирдлагын зарчмаа тохирох байдлаар шүүхээр явснаас илүүгээр мөнгөн урсгал бий болгож, өр төлбөрийг барагдуулах хамтын ажиллагаа болдог.

Шүүхийн бус аргуудыг хэрэглэх гэрээ, хэлцэл, өөрчлөлтийн явц, үр дүнд зээлдүүлэгчид нь хууль ёсоор өр төлбөрөө шаардах эрхээ хадгалах нь чухал бөгөөд хэрэв шүүхийн бус ажиллагаа амжилтгүй болбол шүүхээр шийдвэрлүүлэх боломжоо хадгалж үлдэх нь чухал байдаг.

Зарим улс оронд компанийн өр төлбөрийн дахин зохион байгуулалтын хороо зэргийг байгуулсан сайн туршлага байдаг тул ийм төрлийн хороо байгуулж болох талтай.

Түүнчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг идэвхжүүлэх, олон нийтэд сурталчлах шаардлагатай.

5.3. Чанаргүй активын зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлэх

Монголд чанаргүй активын зах зээл хөгжөөгүй гол шалтгаан нь зээлийн өр төлбөр барагдуулах ажиллагааны үр ашиггүй байдал юм. Тус ажиллагаа нь сунжирсан, таамаглах аргагүй, өрийн бүтцийн өөрчлөлт бараг байхгүй Монголын нөхцөлд хөрөнгө оруулагчид чанаргүй зээлийн багцад доогуур үнэ санал болгох юмуу арилжаанд оролцохоос бүр татгалзана. Чанаргүй зээлийг шийдвэрлэх илүү олон сонголт бий болгох нь зах зээлийг дэмжих ач холбогдолтой.

Чанаргүй активыг худалдах арга хэрэгсэл нь бусад арга хэрэгсэл болох өр төлбөрийг албадан барагдуулах болон дампуурлын ажиллагаа үр ашигтай ажиллаж байгаа үед үр дүнтэй байдаг.

Чанаргүй активыг худалдах арга хэмжээ нь бусад бүх аргын хамгийн сүүлчийнх байх бөгөөд банк тухайн активыг тэнцлээсээ бүрэн салгаж байгаа боловч банкны системийн хувьд сөрөг нөлөөтэй асуудал нь хэвээр үлдэж, бодит эдийн засагт шийдэгдээгүй асуудал хэвээр хоцорно.

Иймд хууль, эрх зүй, шүүх, ШГА, дуудлага худалдаа, дампуурал зэрэг

бусад арга хэрэгсэл бүрэн шинэчлэгдээгүй тохиолдолд активыг худалдах, АУК-д шилжүүлэх нь бүрэн шийдэл биш болохыг анхаарах шаардлагатай.

Активын мэргэшсэн удирдлагын тогтолцоо нь системийн хэмжээнд зээлийн чанар алдагдах хямралын үед санхүүгийн салбарын чанаргүй зээлийн дарамтыг бууруулж, эдийн засагт санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх орчин бүрдүүлдэг. Энэхүү байгууллага нь банкнуудын чанаргүй активыг хямдруулан худалдан авч, банкнуудад санхүүгийн хариуцлага тооцохын зэрэгцээ чанаргүй активт түгжигдээд байсан эх үүсвэр сулран, эдийн засагт эргэлдэх боломжийг бүрдүүлнэ.

АУК-ийг байгуулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхдээ банк, АУК аль аль нь эдийн засгийн утга учиртай харилцаатай байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

АУК-ийг байгуулж, хөгжүүлэх замаар чанаргүй зээлийг худалдах зах зээлийг хөгжүүлэхээр 2018 оны төрөөс баримтлах мөнгөний бодлогын төсөлд тусгасан.

Бусад шинэчлэлийг хийгдсэний дараа шаардлагатай гэж үзвэл АУК-ийн хуулийг УИХ-д өргөн барьж АУК-ийг байгуулж, банкны системийн чанаргүй активын зогсоол бус, хамгийн сүүлийн буюу банк алдагдлаа хүлээсний дараах шийдлийн сүүлийн сонголт хэлбэрээр байгуулах нь зүйтэй. Монголд хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувийн өмчөөр бүрдүүлсэн АУК байгуулах боломжийн талаар хамтарсан ажлын хэсэг судалж байна.

Чанаргүй зээлийг АУК-д шилжүүлэх нь “төвлөрсөн” шийдэл бөгөөд банкнууд болон захын бусад оролцогчийн хоорондын арилжаанд тулгуурласан зах зээлийн шийдлээс ялгаатай юм. Чанаргүй зээлийг борлуулахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, зах зээл бүх хөрөнгө оруулагчдад (тухайлбал, гадаадын) нээлттэй байх, зээлдэгчдийг хамгаалсан үйлчилгээний үүрэг хариуцлага, нөхцөлийг зохицуулах шаардлагатай.

5.4. Зээлдэгчийн талаарх мэдээлэлд хандах боломжийг нэмэгдүүлж, чанаргүй зээлтэй ажиллах үр дүнг сайжруулах

МБ-ны ЗМС нь одоогоор тодорхой зорилтыг хангаж байгаа хэдий ч татвар, гааль, улсын бүртгэл, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, авто тээврийн үндэсний төв, хөдлөх хөрөнгийн бүртгэл, газрын бүртгэл, иргэний бүртгэл зэрэг бусад чухал мэдээллийн төвтэй холбогдоогүй тул зээлдэгчийн талаар иж бүрэн мэдээллийн сан болж чадахгүй байна. Иймд эдгээр мэдээллийн санд зохих хүрээнд цахимаар хандаж, мэдээлэл авах боломжийг зээлдүүлэгчдэд олгох нь чанаргүй зээл үүсэхгүй байх, чанаргүй зээлтэй ажиллахад үр өгөөжөө өгөх учиртай.

Зээлдүүлэгч нь зээлдэгчийн талаар бүрэн судалгаа явуулсны үндсэн дээр зээл олгох нь чанаргүй зээл үүсэхгүй байх нэг нөхцөл тул үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, түүний үнийн талаарх мэдээллийг цахим орчинд ил тод, нээлттэй болгох боломжийг судлах (үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн

газар), зээлдэгчийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх (credit scoring), зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, бусад бүртгэлийн системтэй холбох боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Мөн ЗМС-гийн програм хангамж, үйл ажиллагааг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх, зээлийн тайлагналын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. МБ-наас ЗМС-гийн журмыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.

6. Ажлын төлөвлөгөө

Стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө нь энэхүү стратегийн салшгүй хэсэг юм. МБ-нд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиар олгогдсон бие даасан байдлын дагуу тус банк өөрийн ажлын төлөвлөгөөг баталснаас бусад тохиолдолд ажлын төлөвлөгөө нь МУ-ын Засгийн газрын бүх яам, төрийн бусад байгууллагын үйл ажиллагааг хамрахыг энд онцлон тэмдэглэж байна.

Энэхүү стратегийг Сангийн яам, МБ, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци болон холбогдох бусад байгууллагын оролцоотой хамтран хэрэгжүүлнэ.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь олон байгууллагын хамтарсан ерөнхий төлөвлөгөө бөгөөд ажлын төлөвлөгөө нь хэрэгжүүлэх нарийвчилсан алхам, цаг хугацаа, хүлээгдэж байгаа үр дүн болон эдгээрийг хариуцах байгууллагын жагсаалтаас бүрдэнэ.

Ажлын төлөвлөгөө нь үндсэн стратеги төлөвлөгөөний хавсралт бөгөөд байгууллага тус бүр үүнээс гадна тусдаа ажлын төлөвлөгөөтэй ажиллах үүрэгтэй.

7. Стратегийн хэрэгжилтийг хянах

Энэхүү стратеги нь гурван жилийн тасралтгүй үйл явц байна гэж төлөвлөж байна.

МБ-ны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн А-195/230 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг энэ ажлыг хариуцан удирдаж ажиллана. Тус ажлын хэсэг ажлын хэрэгжилтэд тасралтгүй хяналт тавьж, учирч болох эрсдэл, тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлох үүрэгтэй.

Ажлын хэсэг хагас жил тутам ажлын тайланг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулах үүрэгтэй.

Энэхүү тайланд ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар ирүүлсэн тайлан, мэдээг харгалзан стратегид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг тусгана. Энэ зорилгын үүднээс ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой үйл ажиллагааг хариуцах байгууллага бүр ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар болон ажлын хэсгийн түвшинд хэлэлцүүлэх зарим

асуудлын талаар улирал тутам ажлын хэсэгт тайлагнах үүрэгтэй. Ажлын хэсэг нь төрийн бусад байгууллага, хувьцаа эзэмшигч (олон улсын санхүүгийн байгууллага гэх мэт)-ээс ирүүлсэн зах зээлийн шинэ нөхцөл байдал, өмнө хийгдсэн ажилд чухал нөлөө бүхий бөгөөд дахин авч үзэх шаардлагатай зах зээлийн цаашдын хөгжил, арга хэмжээг анхааралдаа авна.